



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/02

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу сумын Засаг даргын нөөц сангаас Цанын улсын аварга шалгаруулах уралдаан тэмцээнд цанын холбооноос ирсэн зочид, төлөөлөгчдийг хүлээн авах зардалд 489,500 (Дөрвөн зуун наян есөн мянга таван зуун) төгрөг, 2021 оны Онцгой байдал, гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалт, буудлын зардалд 480,000 (дөрвөн зуун наян мянган) төгрөг, Малын гоц халдварт шүлхий өвчний дэгдэлтийн үед 1 дүгээр багт гэр пост ажиллуулахад гэрийн түрээсийн зардалд 390,000 (гурван зуун ерэн мянган) төгрөг, 2022 оны Онцгой байдал, гамшгаас хамгаалах бэлэн байдлын сургалт, буудлын зардалд 165,000 (нэг зуун жаран таван мянган) төгрөг, нийт 1,524,500 (нэг сая таван зуун хорин дөрвөн мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1,524,500 (нэг сая таван зуун хорин дөрвөн мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН